

**Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн
тайлангийн агуулга**

Төсөл хэрэгжүүлэгч “Итгэл түшиг” ХХК-ийн “Завсар” уурхайн төслийн
товч мэдээлэл

1. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл
2. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт
3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
4. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт
5. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
6. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
7. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
8. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт
9. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт
10. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт
11. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт
12. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт
13. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, түүний үр дүнг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөөний биелэлт
14. Дүгнэлт

ОРШИЛ

Төв аймгийн Алтанбулаг сумын нутагт орших “Завсар” нэртэй элс-хайрганы хольцын ордыг ашиглах техник эдийн засгийн үндэслэлийг “Итгэл түшиг” ХХК-ийн төсөл боловсруулах даалгавар, орд газарт 2009 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгээр инженер-геологич С.Алтангэрэл, Б.Гансүх нарын боловсруулсан тайлан болон байр зүйн зураглалын материал, Монгол Улсын Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлийн 2011 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн хуралдааны ХХ-13-09 дүгээр дүгнэлтийг үндэслэн боловсруулав.

2020 оны 03 дугаар сарын 17-ны өдөр Ашигт Малтмал, Газрын Тосны Газрын Кадастрын Хэлтсээс MV-021549 дугаартай Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийг “Завсар” нэртэй 21.27 гектар талбайд олгосон байна.

“Завсар” нэртэй элс-хайрганы хольцын орд нь Улаанбаатар хотоос баруун урагш 45 км-т, Төв аймгийн Алтанбулаг сумын нутагт, Туул голын баруун талын хөндийд, 1978 онд хайгуул хийгдсэн Сонгины элс-хайрганы ордын баруун урд үргэлжлэлд оршино./Хавсралт зураг №1/ Монгол Улсын Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлийн 2011 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн хуралдааны ХХ-13-09 дүгээр дүгнэлт, АМГТГ-ын даргын 2011 оны 08-р сарын 24-ны өдрийн 339 дугаар тушаалаар “Завсар”-ын элс-хайрганы хольцын ордын бодитой (В) нөөцийг 609668.7 м³, боломжтой I нөөцийг 519204 м³ бүгд 1128872.7 м³-ээр улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэсэн байна.

Иймд ордыг ашиглах техник эдийн засгийн үндэслэлийг элс-хайрганы бодитой 609668.7 м³ нөөцөд багтах, усны түвшнээс дээш байгаа 351660.8 м³ нөөцийг олборлохоор уул уурхайн төсөл боловсруулахад баримтлах дүрэм журам, каталог, стандарт, захиалагч талаас тавьсан шаардлагуудад нийцүүлж гүйцэтгэв.

Уурхайн олборлолтын ажлыг ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 21.27 га талбайн 17.3 га-д буюу 2011 онд хийсэн хайгуулын ажлын үр дүнгийн бодитой нөөц тооцсон 173068 м² талбайд тооцоолж төлөвлөв.

Сүүлийн жилүүдэд хотод суурьших хүн амын тоо өсч, хотжилт явагдаж барилга, орон сууц ихээр баригдаж байгаатай холбогдуулан барилгын материалын хэрэгцээ, түүнчлэн хайрганы хэрэгцээ жилээс жилд өссөн нэмэгдэж байна.

Энэ бүтээн байгуулалтын ажилд өөрийн хувь нэмрээ оруулах зорилгоор “Итгэл түшиг” ХХК нь Төв аймгийн Алтанбулаг сумын нутагт Завсар нэртэй газарт Ашигт малтмал, Газрын тосны хэрэг эрхлэх газраас олгосон MV-021549 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийн дагуу түгээмэл тархацтай ашигт малтмал хайрга олборлох үйл ажиллагааг 2023 оноос эхлэн явуулж байна.

Уурхайгаас олборлосон элс хайрганы холимогийг буталж, шигшин угааж 0-5мм, 5-10мм, 10-20 мм байдлаар ангилан ялгасны дараа уурхайн бэлэн бүтээгдэхүүний талбай дээрээс борлуулна.

Физик газар зүй: “Завсар” нэртэй элс-хайрганы хольцын орд нь засаг захиргааны хувьд Төв аймгийн Алтанбулаг сумын нутагт Улаанбаатар хотоос баруун урд зүгт 45км, Шувуун фабрик- Туул тосгоноос баруун хойш 4.5км-т (шулуун зайгаар) Туул голын хөндийд оршино.


“Итгэл түшиг” ХХК нь “Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай” (2014 оны 01-р сарын 09-ний өдөр батлагдсан) хуулийн 14-р зүйлийн дагуу Төв аймгийн Алтанбулаг сумын нутагт орших “Завсар” нэртэй элс-хайрганы хольцын ордын 21.27 гектар талбайд ашигт малтмал ашиглах MV-021549 дугаартай тусгай зөвшөөрлийг Ашигт Малтмал, Газрын Тосны Газрын Кадастрын Хэлтсийн даргын шийдвэрээр 2020 оны 03 дугаар сарын 17-ны өдөр авсан байна. MV- 021549 дугаартай түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Завсар” нэртэй талбай нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн 1:100000 масштабтай байрзүйн зургийн L-48-10-B нэрлэвэртэй хавтгайд оршино. Талбайн тусгай зөвшөөрлийн дугаар, байршлын солбицол, талбайн хэмжээг хүснэгт №1-1-д үзүүлэв.

Ордын оршиж буй тусгай зөвшөөрөлтэй талбайн булангийн эргэлтийн цэгүүдийн солбилцол:

Хүснэгт №1

Талбайн нэр	Тусгай зөвшөөрлийн дугаар	Талбайн булангийн эргэлтийн цэгийн солбилцол (WGS-84 эллипсоидод)		Тэгш өнцгийн солбицол (UTM тусгалд)		Талбайн хэмжээ ээ м ² (га)	Олгосон он
		Уртраг	Өргөрөг	Х	У		
“Завсар” элс-хайрганы хольцын орд	MV-021549	1. 106° 30' 14.61"	47° 45' 31.64"	5290586.5663	612716.7616	21.27	2020 оны 03-р сарын 17
		2. 106° 30' 16.66"	47° 45' 32.30"	5290607.7712	612759.0397		
		3. 106° 30' 18.30"	47° 45' 32.69"	5290620.4751	612792.9447		
		4. 106° 30' 18.30"	47° 46' 21.77"	5292135.6516	612763.4686		
		5. 106° 30' 11.97"	47° 46' 21.77"	5292133.0901	612631.7341		
		6. 106° 30' 11.58"	47° 46' 21.48"	5292123.9796	612623.7917		
		7. 106° 30' 10.52"	47° 46' 20.79"	5292102.2496	612602.1457		
		8. 106° 30' 10.36"	47° 46' 20.70"	5292099.4064	612598.8699		
		9. 106° 30' 13.03"	47° 45' 30.95"	5290564.6257	612684.2852		

Хавсралт зураг №1



“ЗАВСАР” ЭЛС ХАЙРГАНЫ УУРХАЙН /БАЯЖУУЛАХ, БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР/ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

	Үзүүлэлтүүд			Тайлбар	
1	Аж ахуйн нэгжийн нэр			Итгэл түшиг	
2	Улсын бүртгэлийн дугаар			9011057122	
3	Ордын нэр			Доод бөхөгийн хөндий	
4	Хөрөнгө оруулалт /Улсын нэр/			Монгол	
5	Ордын байршил	Аймаг/нийслэл		Төв	
		Сум/дүүрэг		Алтанбулаг	
6	Ашигт малтмалын төрөл			Элс, хайрга	
7	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар			MV-021549	
8	Нөөц	Нөөц бүртгэсэн байгууллага		ЭБЭХҮ, АМГТГ	
		Нөөц бүртгэсэн байгууллагын дүгнэлт, тушаал		АМГТГ 2011 оны 07-р сарын 08-ны өдрийн ХХ-13-09 тоот дүгнэлт, АМГТГ 2011.08.24 дугаар н/339 тушаал	
		Нийт хүдрийн хэмжээ		1128872,7м3	
		Нийтбүтээгдэхүүний хэмжээ			
9	Техник эдийн засгийн үндэслэл	ТЭЗҮ хүлээн авсан байгууллагын дүгнэлт, шийдвэрийн дугаар, огноо		АМГТГ 2021.07.21 т/140 2021.06.02 т/21-10-02	
		ТЭЗҮ боловсруулсан аж ахуйн нэгжийн нэр		“Аргай оч” ХХК	
		Ашиглах нийт хугацаа		7	
10	Уурхайн төрөл	Ил		Ил	
		Далд			
		Баяжуулах, боловсруулах үйлдвэр			
11	Жилийн хүчин чадал	Хүдэр олборлолт	Хэмжих нэгж	Мян.м ³	46.7
		Бүтээгдэхүүн гаргалт		Мян.м ³	43.62
14	2025 онд гаргах бүтээгдэхүүний хэмжээ	Хүдэр олборлолт	Хэмжих нэгж	Мян.м ³	46.7
		Бүтээгдэхүүн гаргалт			43.62
15	Аж ахуйн нэгжийн хаяг	Аймаг/ хот, сум/дүүрэг, баг/хороо, гудамж/байр		Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг, 15-р хороолол 46а байр 17 тоот	
		Гар утас		96362089	
		Цахим хаяг		ltgel_tushig@yahoo.com	
		Тайлан хариуцсан мэргэжилтэнгийн нэр		Ц.Туяа	
		Гар утас		80770068, 96362089	
16	Ашиглалт эхэлсэн огноо			2023	
17	Улсын комисс ажилласан тухай			Хүлээлгэж өгсөн огноо	
				Актын дугаар	

1.Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Элс хайрга олборлох төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд дурдсанаар газрын хэвлийг эвдэж өнгөн хөрс хуулах, карьер нээх, овоолго хийх, олборлох, тээвэрлэх, буталж ангилан ялгаж угаах үйл ажиллагаагаар байгаль дэлхий эвдэрч бохирдохоос гадна тоос гэх мэт агаарт дэгдэх, шатах, тослох материал болон шингэн хаягдал хөрсөнд нэвчих замаар бохирдол үүсч эко системд их бага болон болзошгүй сөрөг нөлөөлөл үзүүлнэ.

Бохирдлын эх үүсвэр нь шороон авто зам, түлш шатахууны агуулах, бохирын цэг, хатуу хог хаягдал, ахуйн химийн бодис зэрэг болно.

2. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт

Ашигт малтмалыг нь авсан хэн бүхний, эх дэлхийгээ хайрлан хамгаалж эвдсэн орчноо нөхөн сэргээх, төлжихөд нь туслах нь бидний үүрэг зорилго бөгөөд зүйн хэрэг мөн болно.

Байгаль орчны нөхөн сэргээлтийг, хуулийн хүрээнд, тогтоол шийдвэр, дүрэм журам, стандартыг үндэслэн уулын ажил болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу ажилласан.

“Итгэл түшиг” ХХК нь элс хайрганы ордыг олборлох ашиглах явцад ашигт малтмалын тухай хуулийг чанд мөрдөн байгаль экологийн хор хөнөөл учруулахгүй уурхайн нөөцийг хаягдалгүй эмх цэгцтэй зөв ашиглахад гол зорилго нь оршино.

Үүнд:

1 Олборлолт явуулан мөргөцөг талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийж боломжийн хэмжээгээр байгалийн онгон төрх оруулах арга хэмжээ авч байх

2. Тусгай зөвшөөрлөөр олгосон эзэмшлийн талбайгаар хүнд даацын машин механизм болон бусад төрлийн тээврийн хэрэгслүүдээр олон салаа зам гарган хөрс ургамалыг эвдэх, түлш шатахуун асгаж хөрсийг бохирдуулахгүй байх.

3. Ахуйн болон шингэн хог хаягдлыг ил задгай асгаж, агаар орчныг бохирдуулахгүй нийт ажиллагсдад болон орчны эрүүл ахуй нөхцлийг чанд хамгаалах.

4. Уурхайн олборлолт хийсэн болон хийгдэж байгаа мөргөцөг орчимд хөдөлмөр хамгаалал техник аюулгүйн санамж тэмдэг тэмдэглэгээ байрлуулж, хол ойрын оршин суугчдад анхааруулга өгч байх

5. Хүчтэй салхи шуурганы үед салхинд туугдсан элс, ойр орчмын засмал зам талбайг хучиж дарах явдлаас урьдчилан хамгаалж далан босгох, мод тарих замаар элсний нүүдлийг зогсоох арга хэмжээ авч ажиллах нь тухайн жилийн гол зорилго болж байна.

3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Элс хайрганы ордын мөргөцөг дотор элс хайрга олборлож тээвэрлэх үед техникийн буруу үйл ажиллагаанаас болж сөрөг нөлөөллүүд үүсч бий болдог. Үүнд уурхайн мөргөцөг дотор элс хайрга олборлож тээврийн хэрэгсэлд ачих үед хуурай шороо хийсч агаар орчныг бохирдуулж хүний эрүүл мэндэд сөрөгөөр нөлөөлж болзошгүй юм. Үүнийг бууруулахын тулд 2024 онд дараах арга хэмжээнүүдийг авч ажилласан болно.

Үүнд

1.. Эксковатор болон ачигч мөргөцөг дотор элс хайрга олборлож байгаа /хуурайшилтын/ үед услаж талбайг чийгшүүлэх замаар тоосжилтын хэмжээг бууруулах арга хэмжээ авч ажилласан.

2. Бульдозер болон ачигчаар уурхай хүртэлх замыг өдөрт нэг удаа хусч замын дэд хэсгийн хуурай сул шороог цэвэрлэж тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр үүсэх тоосжилтийг бууруулж ажилласан.

3. Хүнд машин механизм болон тээврийн хэрэгслүүдийн яндангаас гарах хорт хий / CO_2 , NO_2 , SO_2 / стандартын хэмжээнд байгаа эсэхийг жилд нэг удаа техникийн үзлэгт бүрэн хамруулж шаардлага хангаагүй техникийг ажиллуулахгүй байх арга хэмжээ авч ажиллаж байна.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ : Төсөвт өртөг 1900.0 мян.төг. Энэ ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв.

СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДАЛ

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төгрөг/	Нийт зардал /мян.төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
АГААР ОРЧИН						
Тоосжилт болон бохирдуулагч хийн нөлөөгөөр орчны агаар бохирдох	Уурхайн карьер доторх замд хайрга чулуу дэвсэх, хуурайшилттай үед усалж байсан	0.3 км зам	-	1000.0	2024 он	Агаарын тухай хууль, MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 4990:2010, MNS 0017-2-3-16:1998 MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээ-хэвийн норм, түвшний хэмжээ
	Дизель түлш ашигладаг дотоод шаталт хөдөлгүүрүүд болон машинуудыг ашиглаагүй үед сул асаалттай байлгахгүй байх, шаардлага хангахгүй байгааг нь шинэчлэх		-	-	2024 он	
	Шимт хөрс болон, хөрсний овоолгын гадаргууг нягтруулах, гадаргууг тэгш бус болгох, чийгшүүлж байх; эсвэл зүлэгжүүлэх зэргээр тоосжилт үүсгэхгүй байх	Овоолго үүсгэх талбай	ҮАЗардалд	-	2024 он	
	Хүнд механизмын хөдөлгүүрийн тохиргоо, үйлчилгээг тогтмолжуулах, хөдөлгүүрээс гарах угааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах арга хэмжээ авч ажилласан.	Үйл ажиллагааны турш	300.0		2024 он	
НИЙТ ДҮН				1000.0		
УСАН ОРЧИН						
Ус ашиглах, Ахуйн хаягдал,	Мэргэжлийн байгууллагаар гүний худаг гаргуулж унд ахуйд шаардлагатай усыг хангах. Гүний худагт	Төслийн хүрээнд	ҮАЗ	ҮАЗ	2024 он	

“Завсар” элс хайрганы ордын 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төгрөг/	Нийт зардал /мян.төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
шатах, тослох материал ба бусад хаягдлаас бага гүний уст давхарга болон хөрс ургамал бохирдох	тоолуур, хамгаалалтын бүс тогтоож ажиллах					MNS 13.060.50 Усны чанарын стандарт Усны тухай хууль ЗГ-ын 2013 оны 326 дугаар тогтоолын хавсралт –Ус ашигласаны төлбөрийн хувь хэмжээ/ Газар доорх усыг бохирдлоос хамгаалах: MNS3342:1982 БО, ЭМНХ-ын сайдын 1997 оны 143А, 352/А тоот хамтарсан тушаалын 2.3.5 хавсралт,
	Гол, мөрний байгалийн үндсэн голдирлыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэргүйгээр өөрчлөхгүй байх ёстой.	Үйл ажиллагааны турш	-	-	2024 он	
	Ус ашиглах дүгнэлт, гэрээг байгуулж ажиллах.Төсөл хэрэгжүүлэгч нь “Усны тухай хууль” –ийн 28.4 –р зүйлд зааснаар“Ус ашиглах дүгнэлт” –ийг аймгийн байгаль орчны албанаас гаргуулна.Ус ашиглах дүгнэлтийг үндэслэн ус ашиглах зөвшөөрлийг Хонгор сумын Засаг даргатай холбогдох гэрээг байгуулж ажиллах шаардлагатай.	Уурхай ажиллах нийт хугацаанд	Ашиглах усны хэмжээгээр	-	Жил бүр ашиглалтын хэмжээгээр	
	Шатах, тослох материалын хаягдал, асгаралт гаргахгүй байх арга хэмжээ авч ажилласан.	Үйл ажиллагааны турш	200.0	500.0	2024 он	
	Бороо цас үерийн ус цуглуулахсан байгуулах, тоосжилт дарах зорилгоор хэрэглэх, үерээс хамгаалах далан байгуулах	Боломжит газрыг сонгох ажиллах хугацаанд			2024 он	
Нийт дүн			500.0			
ХӨРС, УРГАМЛАН БҮРХЭВЧ						
Хөрс элэгдэл эвдрэлд орж үржил	Ил уурхай, овоолго байгуулах талбайн үржил шимт хөрсийг хуулж, 2 м-ээс өндөргүй	Үйл ажиллагааны турш	-	ҮАЗардалд	2024 он	MNS 3307:1991, MNS 3308:1991

“Завсар” элс хайрганы ордын 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төгрөг/	Нийт зардал /мян.төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
шим, чийг буурах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	овоолон хадгалах, овоолгыг салхины нөлөөнөөс хамгаалах					Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5915:2008
	Уурхайн дотоодтээвэрлэлтийн замыг хайрган хучилттай болгох	Үйл ажилллагааны турш	-	ҮАЗардалд	2024 он	
Тээвэрлэлтийн улмаас хөрсний эвдрэл үүсэх	Замыг тэмдэгжүүлж, салаа зам гаргахаас сэргийлсэн ухуулах самбар хийж байрлуулах,	Төслийн талбайд			2024 он	
Ахуйн хаягдал, шатах, тослох материал алдагдах, хөрс бохирдох	Шатах, тослох материал, ажилласан тосны хаягдлыг зориулалтын саванд хадгалах, орчинд асгарч алдагдахаас сэргийлэх,	Үйл ажиллагааны турш	100.0	400.0	2024 он	
	ШТМ, агуулах болон засварын төвийн талбайг хатуу хучилттай болгож газрын гадарга, хөрс бохирдохоос сэргийлэх	Агуулахуудын орчимд	-		2024 он	
	Хог хаягдлыг тухай бүрт нь ангилан зайлуулах арга хэмжээ авах	Төслийн талбайд		-	Тухай бүрд	
Нийт зардал				400.0		
Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний зардал				1900.0		

2024 онд байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 3

№	Хийгдсэн ажлууд	Зардал, мян.төг	тайлбар
1	Ахуйн шингэн хаягдлыг тусгайлан доторлосон нүхэнд хуримтлуулан битүүмжлэх, ариутгал, устгал хийх	300.0	Бүгд биелсэн Ариутгал 2 удаа хийгдсэн
2	Хөрсийг ямар нэг химийн бодисоор бохирдуулах, шатах тослох материалыг ил задгай асгахыг хориглох		Энэ ажил хэвшсэн
3	Ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлыг эмх цэгцтэй төвлөрүүлэх нэг цэг байгуулах	-	Энэ ажил хийгдэж хэвшсэн
4	Машин техникийн үйлчилгээ, засварыг тусгай бэлтгэсэн талбайд явуулж хэвших	-	Энэ ажил хийгдэж хэвшсэн
5	Төв зам болон орд хүрэх зам дагуу, ордын талбай, үйлдвэр орчимд замыг тэмдэгжүүлэх	-	Энэ ажил хийгдсэн
6	Гал түймэр гарахаас сэргийлэх арга хэмжээг авч, түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, булан цэгүүд бэлтгэсэн байх.	-	Энэ ажил хийгдсэн
7	Элс-хайрга олборлох, тээвэрлэх ажлыг геологи, уул техникийн нөхцөл, зураг төслийн дагуу хийх	-	Уулын ажлын төлөвлөгөөний дагуу хийсэн
8	Уурхай орчмын замын тоосыг усалгаа хийж бууруулсан	500,0	Төлөвлөгөөний дагуу хийдэг
	дүн	800,0	Бүгд биелсэн

4. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

4.1 Техникийн нөхөн сэргээлт хийгдээгүй.

4.2 Биологийн нөхөн сэргээлт

Биологийн нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа нь техникийн үе шат бүрэн дуусаж, овоолгын болон талбайн хөрс чулуулаг тогтворжиж, нягтарсны дараа овоолгод хадгалж байсан шимт хөрсийг эргүүлэн байршуулах замаар биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийдэг.

Тэр бум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд ногоон байгууламжыг нэмэгдүүлэх үүднээс байгаль орчны нарийвчилсан үнэлгээ болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгаснаар уурхайн орчимд 2000м² буюу 0.2 га талбайд 20 ширхэг мод тарьсан. Мод тарих ажиллах хүч, усалгаанд 700,000₮ нийт зарцуулсан.

5. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Энэхүү ажлын хүрээнд Төв аймгийн Алтанбулаг сумаас баруун тийш 60км Алтан овоо нэртэй газарт үерийн улмаас эвдэрч машин, хүн явахад хүндрэлтэй болсон газрыг тэгшилж , дүүргэж өгөх ажлыг 3 хоногийн хугацаанд 2 ковшоор хийж гүйцэтгэлээ. Түлш шатахуун ажилчидын ажлын хөлс нийт зардал 6300.0 мян.төг болсон.

6. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Манай уурхайн хүрээнд дээрхи ажил хийгдээгүй.

7. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Манай уурхайн хүрээнд хамааралгүй. Учир нь уурхайн объект орчмын нутаг дэвсгэрт археологи, палентологийн болон түүх, соёлын өв, дурсгалын зүйл байхгүй.

8. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Манай уурхайн хүрээнд хамааралгүй. Учир нь уурхайд химийн бодис хэрэглэдэггүй.

9. Осол , эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт №4

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэрэгжилт /Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжиж байгаа, Төлөвлөж байгаа/	Хэрэгжилт
1	Цаг агаарын гэнэтийн үзэгдлээс үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох	Цаг агаарын улирлын, сарын, 7 хоногийн, өдөр тутмын урьдчилсан мэдээнүүдийг төслийн үйл ажиллагаанд тогтмол ашиглах	“Итгэл түшиг” ХХК-ний ажилчид	Бүрэн хэрэгжсэн	Цаг агаарын мэдээг 7 хоног бүр гарган нийт ажилчдад танилцуулан, арга хэмжээг авч ажилласан.
2	Гал түймрийн улмаас үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох	Гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, болзошгүй аюулын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчдад тогтмол хугацаанд танилцуулах	Итгэл түшиг” ХХК-ний ажилчид	Бүрэн хэрэгжсэн	Хийгээгүй

3		Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, галын хор зэргийг тогтсон стандартын дагуу байрлуулж бэлэн байдлыг хангаж ажиллах	Итгэл түшиг” ХХК-ний ажилчид	Бүрэн хэрэгжсэн.	Шаардлагатай цэгүүдэд галын хор, санамж бичиг галын сарааг байршуулсан.
4	Газар хөдлөлт, чичирхийллийн улмаас	Болзошгүй ослын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчидад тогтмол хугацаанд танилцуулах	Итгэл түшиг” ХХК-ний ажилчид	Бүрэн хэрэгжсэн	Ажил эхлэхийн өмнө нийт ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч ажиллаж байна. АА-ны зөрчилгүй ажилласан.
6		Ажиллагсдын хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах	Итгэл түшиг” ХХК-ний ажилчид	Бүрэн хэрэгжсэн	Нийт ажилчдад хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслийг хуваарилан өгч, шаардлагатай нэг бүрийг хэрэгслийг өгч ажилласан.
7	үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох	Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдалд тогтмол хяналт тавьж, засвар үйлчилгээг тогтмол хийж байх	Итгэл түшиг” ХХК-ний ажилчид	Бүрэн хэрэгжсэн	Тогтмол хяналт тавьж ажилласан. 2024 онд гаргасан зөрчилгүй.

“Итгэл түшиг ” ХХК нь цаг агаарын мэдээг 7 хоног тутам гарган нийт ажилчдад танилцуулан, тухайн нөхцлөөс шалтгаалан арга хэмжээг авч ажилласан. Онцгой байдлын ерөнхий газар “Гамшгаас хамгаалах тухай ойлголт, гамшгаас хамгаалах хууль тогтоомж” гэсэн агууллагатай сургалтыг нийт ажилчдад танилцуулж, сургалт зохион байгуулсан

Шаардлагатай цэгүүдэд галын хор, санамж бичиг галын сарааг байршуулсан байдал



10. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Бид өөрсдийн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдалын хэмжээг хамгийн бага байлгах , дахин ашиглагдахгүй хог хаягдалыг байгаль орчинд ээлтэй технологиор устгах, булах ажилд нэн тэргүүний ач холбогдол өгч ажилладаг.

Уурхайн олборлолт явагдаж байгаа мөргөцөг дотор ямар нэгэн хог хаягдал үүсч бий болдоггүй юм. Компанийн захиргааны байр орчимд техникийн хог хаягдал / хатуу/ мөн шингэн хэлбэрийн ахуйн хог хаягдал үүсч бий болоод уг хог хаягдлыг ил задгай хаяснаас болж зуны улиралд янз бүрийн үнэр орж, агаарт уурших замаар хүний эрүүл мэндэд сөрөгөөр нөлөөлөх явдал гарах магадлалтай юм.

Үүнээс болгоомжлохын тулд: Ахуйн шингэн хог хаягдлыг нүх ухаж элс шороогоор дарж ялаа, шумуул шавьж, үнэр гаргуулахгүй арга хэмжээ авч ажиллаж байна.

Техникийн хатуу хог хаягдлуудыг зориулалтын битүү төмөр саванд цуглуулж байгаад тээврийн хэрэгсэлд ачиж хол тээвэрлэж хогний цэгт асгаж байна. Бид өөрсдийн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдалын хэмжээг хамгийн бага байлгах , дахин ашиглагдахгүй хог хаягдалыг байгаль орчинд ээлтэй технологиор устгах, булах ажилд нэн тэргүүний ач холбогдол өгч ажилладаг.

Энэ ажлын хүрээнд уурхай дээр хог агуулах цэг байгуулсан, төлөвлөгөөний биелэлт хангалттай гэж үзэж байна. Үйлдвэрийн объект бүрт хог хаягдлыг ангилан ялгаж хаях зориулалтын хогийн сав ба хатуу хог хаягдлыг түр байршуулах цэг байгуулсан. Үүгээр үйлдвэрийн талбайд хатуу хог хаягдалгүй, хог хаягдал тархалтыг бүрэн хязгаарласан, эмх цэгцтэй байх нөхцлийг бүрдүүлж чадсан.

Хог, хаягдалын менежментийн арга хэмжээний зардал

Хүснэгт №5

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нийт зардал мян.₮	Хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох	Ахуйн хаягдлыг ангилах дахин ашиглах зүйлсийг цуглуулах цэг байгуулах, нэгдсэн цэгт тушаах арга хэмжээг авч ажилласан.	Үйл ажиллагааны турш	600,0	Сар бүр	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
	Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийх, ажилчдынбайр, ШТС зэрэг газарт байрлуулсан.	Үйл ажиллагааны турш	-	2024 онд	
	Хаягдал дугуй болон төмрийн хаягдлыг ангилан ялган цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлсэн	Үйл ажиллагааны турш	-	2024 онд	
	Хаягдал ажилласан тосыг тусгай саванд цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт өгсөн	Үйл ажиллагааны турш	-	2024 онд	
Шингэн хог хаягдлаар хөрс, газар доорх ус бохирдож болзошгүй	Бие засах газар, бохирын худгийг MNS 5924 : 2015 “Нүхэн жорлон, угаадасны нүх.Техникийн шаардлага” стандартын дагуу барьж ашигласан.	Ажилчдын сууринд	-	2024 онд	Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль,
Хийн хаягдал их гарч агаар орчин бохирдож болзошгүй	Агаар бохирдуулах эх үүсвэр тутмын ялгарлыг бууруулах техник технологийн шийдлүүдийг төслийн эхэн үеэс эхлэн шийдвэрлэж, хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажилласан.	Агаар бохирдлын төлбөрийн заалтаар	ҮАЗардалд тусгах	2024 онд	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS5885:2008
НИЙТ ДҮН			600,0		

11. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

Байгаль орчныг хамгаалж, нөхөн сэргээхэд “Завсар” элс хайрганы ордыг ашиглах төслийн ТЭЗҮ, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, төслийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, нөхөн сэргээх төсөл, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу ажилласан.

- Уурхайн хүчин чадал бага тул удирдлагын нүсэр бүтэц байх шаардлагагүй юм. Иймд байгаль орчныг хамгаалах, хяналт тавих, нөхөн сэргээлт хийх ажлыг компаний захирал уурхайн дарга, инженерүүд хариуцан гүйцэтгэх бөгөөд жил бүр гүйцэтгэх ажлын хэмжээ болон зардлыг байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаснаар ажиллав.
- Нөхөн сэргээлт болон байгаль орчныг хамгаалах ажлыг урьдчилан төлөвлөсний дагуу дэс дараалалтай хийж гүйцэтгэсэн.
- Компаны удирдлага нь байгаль орчны холбогдолтой бүх хууль журмын дагуу уурхайн үйл ажиллагааг удирдан зохион байгуулахаас гадна хуулийн өмнө хариуцлага хүлээнэ.
- Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт шинжилгээ хийлгэсэн дүнг заасан хугацаанд холбогдох байгууллагад хүргэж тайлагнаж байна.
- Уурхайн ажиллагсадын ихэнх нь тоосжилт, дуу чимээ, доргио, чичиргээ ихтэй, температурын эрс өөрчлөлттэй, нөхцөлд ажилладаг тул хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, зориулалтын ажлын нормт хувцасаар хангаж ажилласан.

12. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт

Тухайн жилийн менежментийн төлөвлөгөөг болон биелэлтийг холбогдох байгуулага болох Байгаль орчин ногоон хөгжлийн яамаар батлуулж, ажилласан болно.

Байгаль орчныг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хамгаалж, хадгалах талаар удирдлагын зүгээс онцгой анхаарал тавьж, нөхөн сэргээлт хийсэн талбайг стандартын дагуу хийлгэж, уурхайн ойр орчны хүн малын аюулгүй нөхцөл байдлыг хангах зорилгоор олборлолт хийсэн.

Мөргөцөгийн талбайн ирмэг дагуу хамгаалалт хийж, унаж бэртэхийг сануулсан самбар, тууз татаж орон нутгийн хүмүүст анхааруулга өгч танилцуулах ажлыг зохион байгуулсан байна.

13. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн талаар хийсэн ажил

Уурхайн олборлолтын үед тус орд газарт ажиллаж байгаа, хүнд машин механизм, болон тээврийн хэрэгслүүдийн явах зам дагуу хуурайшилтын үед тоос шороо хийсч орчны агаарыг бохирдуулж, тэнд ажиллаж байгаа хүмүүсийн эрүүл мэндэд сөрөгөөр нөлөөлөх явдал гарч болзошгүй юм.

Орд нь улиралын чанартай ажилладаг учраас ихэнхдээ чийгтэй хур бороотой үед олборлолт явуулдаг тул орчны агаарыг бохирдуулахаар нөлөөлөл ажиглагдахгүй юм.

Агаарын тоосжилт харьцангуй багассан. Хүнд даацын машин явах замууд хийгдэж аж ахуйн нэгжүүд хамтарч өөр өөрийн орчиндоо арчилгаа засвар хийдэг болсон.

Ус нь хими, нян судлалын шинжилгээний тухайн шинжлэгдсэн үзүүлэлтүүдээр химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн 1- р төрлийн цэнгэг зөөлөн, Монгол Улсын “Хүрээлэн буй орчин, Эрүүл мэндийг хамгаалах, Аюулгүй байдал, Ундны ус, Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ MNS-900-2005 стандартын шаардлагыг хангаж байгаа.

. Агаарын тоосжилт харьцангуй багассан. Агаар, ус , хөрсний шинжилгээг БОХЗТЛабораторид хийлгэсэн.

Хүснэгт №6

Хяналт	А.	Б.	В.	Г.
шинжилгээний дээж	Дээж авах цэгийн тоо	Дээж авах цэгийн байршил	Давтамж	Төсөв /мян.төг/
Хөрс	1	Карьер орчимд,	Жилд 1 удаа	113.5
Агаар	1	Карьер орчимд,	Жилд 1 удаа	49.5
Нийт				163.0

14. Дүгнэлт

Байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний тухайн жилийн төсөв, биелэлтийг Хүснэгт №5 -д үзүүлэв.

Хүснэгт №7

д/д	Мэдээллийн төрөл	мян. төг биелэлт	тайлбар
1	Тухайн жилийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нийт төсөв	10463.0	
2	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	800.0	
3	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	600.0	
4	Нөлөөллийг бууруулах арга хэмжээний төсөв	1900.0	
5	Нөхөн сэргээх арга хэмжээний төсөв / техникийн /		
6	Нөхөн сэргээх арга хэмжээний төсөв / биологи /	700.0	
7	Дүйцүүлэн хамаалах арга хэмжээний зардал	6300.0	
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн талаар хийсэн ажил	163.0	
9	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт		
10	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төсөв	-	
11	1. Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төсөв	-	хамааралгүй

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт



Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт



Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт



Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт



Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт



Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт



Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт



2024 ОНД ХИЙСЭН БИОЛОГИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ



2024 онд олборлолт явуулсан талбайн солбицол: (WGS-84,UTM тусгагд)

Д.д	X	Y	B	L
1	5291317.04	612642.62	47 45 55.33	106 30 11.73
2	5291316.48	612661.81	47 45 55.30	106 30 12.65
3	5291212.92	612692.49	47 45 51.93	106 30 14.02
4	5291243.09	612285.62	47 45 53.16	106 29 54.51
5	5291248.83	612776.88	47 45 53.04	106 30 18.11
6	5291191.05	612779.78	47 45 51.17	106 30 18.20
7	5291169.41	612652.82	47 45 50.55	106 30 12.08

